

ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛ

АНУ: АНУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд буурч хаагдаа. Урт хугацаат Засгийн газрын бондын өгөөж буурч, S&P 500 индексийн сагсанд багтдаг цахилгаан, ус, дулаан хангамжийн компаниудын хувьцааны ханш өссөн үзүүлэлттэй байна.

Дэлхийн эдийн засгийн өсөлт удааширч байгаа гэсэн хүлээлт хөрөнгийн зах зээлд сөргөөр нөлөөлжээ.

АНУ, БНХАУ хоорондын худалдааны маргааны асуудал хөрөнгийн зах зээлд нөлөөлсөн хэвээр байна. Өнгөрсөн долоо хоногт АНУ БНХАУ-ын "Huawei" компанийн Санхүү хариуцсан захирлыг баривчлах талаар Канадад хүсэлт тавьж АНУ, БНХАУ-ын харилцаанд бас нэгэн хагарал үүссэн билээ. Харин энэ долоо хоногт тус явдалтай холбоотойгоор Канад улсын 2 иргэнийг Хятад улсад саатуулснаар 2 улсын харилцаа муудсан байна.

Лхагва гарагт АНУ, БНХАУ хоорондын худалдааны маргааны асуудалд эерэг өөрчлөлт гарч, хөрөнгийн зах зээлийн индексүүд өсч эхэлжээ. БНХАУ АНУ-аас ахин шар буурцаг экспортолж эхэлсэн байна.

Сүүлийн 2 сарын хугацаанд өсөөд байсан АНУ-ын ажилгүйдлийн тэтгэмж хүсэгчдийн тоо огцом буурч, сүүлийн 50 жилийн доод түвшинд хүрчээ. Мөн 11-р сард жижиглэнгийн худалдаа нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Европ: Европын бүсийн хөрөнгийн зах зээлийн индексүүд өссөн үзүүлэлттэй байгаа ч еврогийн ханш ам. долларын эсрэг суларчээ. Энэ нь Европын төв банк зээлийн хүүний түвшинг хэвээр үлдээж, сар бүрийн бонд худалдан авалтаа зогсоосонтой холбоотой аж.

Европын эдийн засгийн судалгааны институтээс мэдээлснээр Герман улсын эдийн засаг таамагласан хэмжээнээс илүү хурдацтай өссөн байна. Харин Францын Ерөнхийлөгч ноён Эммануэль Макрон татварын хэмжээг бууруулж, цалингийн хөлсний хэмжээг нэмэн, бослого гаргаад байсан "шар хантаазтангууд"-ын суллах талаар мэдээлснээр тус улсын хөрөнгийн зах зээлийн индексүүд өсчээ. 11-р сард Герман болон Франц улсын борлуулалтын менежерүүдийн индекс буурсан үзүүлэлттэй байна.

Европын удирдагчид BREXIT-ийн хэлэлцээрийн төсөлд өөрчлөлт оруулахгүй байхад санал нэгдэв. Үүнээс өмнө Их Британийн Ерөнхий сайд Тереза Мэй Консерватив намын итгэл үзүүлэх эсэх санал хураалтад ялалт байгуулсан юм.

Япон: Японы хөрөнгийн зах зээлийн Nikkei 225 индекс буурав.

3-р улиралд Япон улсын эдийн засаг тус улсын Засгийн газрын урьдчилан тооцсон хэмжээнээс 2 дахин их хэмжээгээр буурав. Япон улсын эрэлт болон хөрөнгө оруулалтын хэмжээ буурсан нь тус улсын эдийн засаг 2.5%-аар буурах гол шалтгаан болжээ.

Эх сурвалж: Reuters, Troweprice

Олон улсын индексүүд

Индекс	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	20,393.95	4.66% ▲
Dow Jones	АНУ	24,100.51	-1.18% ▼
S&P 500	АНУ	2,599.95	-1.26% ▼
Nasdaq	АНУ	6,910.66	-0.84% ▼
S&P/TSX	Канад	14,595.07	-1.35% ▼
FTSE 100	Их Британи	6,845.17	0.99% ▲
S&P/ASX 200	Австрали	5,602.00	-1.40% ▼
Nikkei 225	Япон	21,374.83	-1.40% ▼
Hang Seng	Хонг Конг	26,094.79	0.12% ▲

Бондын өгөөж

Бонд	Валют	Купон	Үнэ
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.750%	107.44
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.625%	95.32
Mongol 2022 (Чингис)	USD	5.125%	94.46
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.875%	110.67
DBM' 23 (Самурай)	JPY	1.520%	104.72
DBM' 2023	USD	7.250%	98.82
TDBM' 2020	USD	9.375%	104.42

Зах зээлийн хүү

Хүү	Хаалт	Өөрчлөлт
Libor 1M	2.455	0.06 ▲
Libor 3M	2.800	0.03 ▲
Libor 6M	2.900	0.01 ▲
Libor 1YR	3.090	-0.01 ▼
US 2YR Bond	2.735	0.04 ▲
US 3YR Bond	2.729	0.03 ▲
US 5YR Bond	2.732	0.06 ▲
US 10YR Bond	2.891	0.06 ▲

Валютын ханш /төг/

Валют	2018.12.14	Өөрчлөлт
USD	2,634.99	0.02% ▲
CNY	382.22	-0.13% ▼
EUR	2,992.69	-0.10% ▼
RUB	39.68	0.69% ▲
KRW	2.33	-0.85% ▼
JPY	23.20	-0.68% ▼
CAD	1,968.76	0.09% ▲

Түүхий эдийн үнэ

Түүхий эд	Хэмжих нэгж	Хаалт	Өөрчлөлт
Алт /спот/	USD/t oz.	1,238.69	-0.75% ▼
Мөнгө /спот/	USD/t oz.	14.62	0.34% ▲
Зэс	USD/lb.	275.40	0.55% ▲
Нүүрс	USD/MT	102.80	0.78% ▲
WTI газрын тос	USD/bbl.	51.31	-2.12% ▼
Brent газрын тос	USD/bbl.	60.36	-2.49% ▼
Байгалийн хий	USD/MMBtu	3.63	-20.39% ▼

Макро эдийн засгийн үзүүлэлтүүд

Үзүүлэлт	Хугацаа	Хэмжээ
Инфляцийн түвшин	2018. X	6.30%
Бодлогын хүү	2018. XI	11.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2018. X	10.00%
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2018. X	12.30%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2018. X	5.40%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2018. X	17.40%
Зээлийн дундаж хүү /валют/	2018. X	10.70%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Bloomberg

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА


Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн бирж дээр 69 компанийн 1,657.8 сая төгрөгийн 5,855,391 ширхэг хувьцаа арилжигдав.

“Шивээ овоо” /SHV/ компанийн хувьцаа 34.13%-аар буюу хамгийн ихээр өсч 2,295 төгрөгт хүрч хаагдсан бол “Женко тур бюро” /JTB/ компанийн хувьцаа 22.35%-аар буурч 66 төгрөгт хүрч хаагдлаа.

Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч болон хоёрдогч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.


12-р сарын 14-ны өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,398.4 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 Индекс 20,393.95 нэгж болж өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 4.66%-аар өссөн байна.

MSE Индекс



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Арилжааны үнийн дүн /7 хоногоор, 2018 он/



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Зах зээлийн хураангуй

Хураангуй	Үнийн дүн /сая төг/
Арилжигдсан үнийн дүн	1,657.8
Зах зээлийн үнэлгээ	2,398,391.3

Зах зээлийн индекс

Индекс	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	20,393.95	4.66% ▲
MSE I индекс	9,734.75	4.73% ▲
MSE II индекс	8,769.12	2.04% ▲

Идэвхтэй арилжигдсан хувьцаа

Компани	Ширхэг	Үнийн дүн /төг/
АПУ	1,191,888	689,843,768
Ард даатгал	301,172	224,887,683
Мандал даатгал	32,970	167,164,870
Говь	428,390	154,745,088
Сүү	524,402	106,603,495

Өсөлттэй хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Шивээ овоо	2,295.00	34.13% ▲
Орхон хөгжил	285.92	32.25% ▲
Монгол савхи	724.50	31.73% ▲
Тахь-ко	13,400.00	31.37% ▲
Оллоо	74.70	24.50% ▲

Бууралттай хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Женко тур бюро	66.00	-22.35% ▼
Хөвсгөл алтан дуулга	960.00	-15.79% ▼
Орхон далай	1,800.00	-14.29% ▼
Хай би ойл	33.10	-13.91% ▼
Багануур	1,471.00	-12.39% ▼

Арилжаанд идэвхтэй оролцсон үнэт цаасны компаниуд

Компани	Арилжааны үнийн дүн /төг/
Би Ди Сек	1,506,164,510
Голомт капитал	563,547,220
Ард секюритиз	473,772,267
Бумбат-Алтай	210,902,835
Ти Ди Би Капитал	136,679,530

Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани

Компани	Хаалт /төг/	ЗЗҮ /сая.төг/
АПУ	600.00	638,509
Таван толгой	7,000.00	368,656
Говь	363.33	283,438
МИК	10,300.00	213,306
Сүү	210.00	72,240

ЗГҮЦ БОЛОН КОМПАНИЙН БОНДЫН АРИЛЖАА

ЗГҮЦ-ны анхдагч зах зээл

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
-	-	-	-	-	-	-	-

ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээл

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
-	-	-	-	-	-	-	-

НОГДОЛ АШГИЙН МЭДЭЭЛЭЛ

№	Симбол	Компанийн нэр	Нэгж хувьцааны ногдол ашиг /төг/	Нийт ногдол ашиг /сая төг/	Шийдвэр огноо	Бүртгэлийн өдөр	Хуваарилах өдөр
1	HRM	Гермес центр	5.00	392.72	2018.08.31	2018.09.10	2018.10.10-нд олгов
2	ERS	Монгол алт	150.00	39.88	2018.04.27	2018.04.05	2018.12.31-ний дотор
3	TEE	Тээвэр дархан	500.00	81.67	2018.04.27	2018.04.05	2018.12.31-ний дотор
4	TTL	Таван Толгой	2,410.00	126,923.13	2018.04.16	2018.04.03	2018.06.12-нд олгов
5	EER	Ариг гал	21.33	74.21	2018.04.25	2018.04.02	2018.09.01-с
6	BDL	Могойн гол	100.00	82.96	2018.04.26	2018.01.18	2018.06.26-нд олгов
7	DSS	Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ	56.60	7.66	2018.03.07	2018.03.27	2018.07.02-с
8	TAL	Талын гал	50.00	34.71	2018.03.05	2018.04.26	2018.12.31-ний дотор
9	BRC	Барилга корпораци	700.00	28.46	2018.02.24	2018.03.16	Тодорхойгүй
10	AND	Анд-Энерги	1.27	99.15	2018.02.24	2018.03.16	Тодорхойгүй
11	SUL	Жуулчин дюты фрий	10,000.00	653.62	2018.02.23	2018.04.11	2018.05.01-с
12	GTL	Гутал	1,270.00	83.01	2018.02.19	2018.03.18	2018.07.06-с
13	BNG	Баянгол зочид буудал	355.00	150.19	2018.02.19	2018.04.06	2018.09.01-с
14	APU	АПУ	10.00	10,641.82	2018.02.19	2018.03.29	2018.05.17-нд олгов
15	BTG	Баянтээг	100.00	25.26	2018.02.19	2018.03.12	2018.06.01-ний дотор
16	MIE	Материалимпекс	10.00	13.68	2018.02.19	2018.03.26	2018.04.17-нд олгов
17	HRD	Хүрд	497.00	67.23	2018.02.15	2018.02.23	2018.06.30-ны дотор
18	SUU	Сүү	3.00	1,032.00	2018.02.14	2018.04.05	2018.06.04-нд олгов
19	MNP	Монгол шуудан	3.68	366.48	2018.02.13	2018.04.13	2018.06.05-нд олгов
20	MMX	Махимпекс	100.00	380.07	2018.02.13	2018.04.05	2018.10.01-с
21	TCK	Талх чихэр	170.00	174.03	2018.02.12	2018.04.06	2018.07.01-с
22	GHC	Ган Хийц	100.00	24.25	2018.02.09	2018.03.06	2018.09.21-нд олгов
23	ADL	Адуун чулуун	130.00	409.67	2018.02.07	2018.03.01	2018.06.26-нд олгов
24	TAH	Тахь-ко	108.00	128.52	2018.02.05	2018.03.30	2018.05.01-ний дотор
25	UBH	Улаанбаатар хивс	100.00	40.48	2018.02.05	2018.02.26	2018.05.01-с
26	GOV	Говь	220.00	1,716.25	2018.02.02	2018.03.27	2018.04.24-с олгов
27	HRM	Гермес центр	5.00	392.72	2018.01.24	2018.02.15	2018.04.12-нд олгов

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

“Говь” ХК-ийн арилжааг сэргээхээр боллоо

Санхүүгийн Зохицуулах Хорооны Улсын байцаагчийн 2018 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 58 тоот албан шаардлагаар “Говь” ХК-ийн хувьцааны арилжааг 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдөр нээхээр болсон.

Тус компанийн үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулахтай холбогду үнэт цаасны арилжааг 2018 оны 12 дугаар сарын 03-ны өдрөөс эхлэн түр зогсоогоод байсан билээ.

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Хоёр гишүүн ҮЦК-ийн гишүүнчлэлийг эрхийг цуцаллаа

Монгол Улсын Компанийн тухай хууль болон СЗХ, МХБ-ийн холбогдох дүрэм, журамд нийцүүлэн гаргасан “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 2018/17 тоот тогтоолоор “Би Би Эс Эс ҮЦК” ХХК, “Говийн ноён нуруу ҮЦК” ХХК-иудын биржийн гишүүнчлэлийн эрхийг цуцалж, гишүүнээс хаслаа.

Тус компаниудын харилцагчдыг СЗХ-ны 2018 оны 4 дүгээр сарын 04-ний өдрийн 127 тоот тогтоолын дагуу “Бумбат Алтай ҮЦК” ХХК-д шилжүүлсэн тул гишүүнээс хасагдсан дээрх компаниудын харилцагчид нэмэлт төлбөр, зардал чирэгдэлгүйгээр үнэт цаасны дансаа үргэлжлүүлэн эзэмшиж, хөрөнгийн зах зээлийн харилцаанд саадгүй оролцох боломжтой юм.

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Шинээр гаргах хувьцааг бүртгэж, “МИК актив 18” ХХК-д зөвшөөрөл олголоо

Санхүүгийн зохицуулах хорооны ээлжит хуралдаан 12-р сарын 14-ны өдөр болж өнгөрлөө.

Өндөгний үйлдвэрлэл, худалдаа эрхэлдэг “Түмэн шувуут” ХХК-ийн гаргаж буй нэг бүр нь 20 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 200,000,000 ширхэг энгийн хувьцаа бүртгэлээ. Тус компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаас компанийн нийт хувьцааны 25 хувийг олон нийтэд анх удаа санал болгон гаргаж “Монголын хөрөнгийн бирж” ХК-аар дамжуулан арилжихаар шийдвэрлэснийг хэлэлцэн, дээрх 200 сая ширхэг хувьцааны 50,000,000 ширхэгийг тогтоосон үнийн аргаар тус бүрийн үнийг 200 төгрөгөөр нийтэд санал болгон худалдахыг зөвшөөрлөө. Үнэт цаас гаргагчийн андеррайтераар “Голомт капитал ҮЦК” ХХК ажиллаж байгаа бөгөөд хувьцааг 100 хувь арилжаалсан тохиолдолд анхдагч зах зээлд үнэт цаас нээлттэй худалдах ажиллагаа амжилттай болсонд тооцохоор тогтов.

Мөн хуралдаанаар, “МИК актив арван найм” ХХК-д хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгож, тус компанийн гаргаж буй 100,000 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий, 30 хүртэл жилийн хугацаатай, орон сууцны зээлээр баталгаажсан нийт 950,068 ширхэг баталгаат үнэт цаасыг бүртгэлээ.

Түүнчлэн, “Баян-Алдар” ХК-ийн үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулж, ХААБ-ийн арилжааны зуучлагч “Мэту ХААБ”, “Ханбүргэд Хэнтий ХААБ”, “Алтаншагай импекс ХААБ”, “Бадархундага оргил ХААБ”, “Сантланс ХААБ”, “Баярлант ХААБ” ХХК-уудын үйл ажиллагааны талаар авах зарим арга хэмжээний тухай тогтоол гаргалаа.

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

МҮЦБ арилжааны төлбөр тооцооны Т+2 горимд шилжлээ

Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2018 оны 8-р сарын 2-ны өдрийн 456 тоот тушаалаар батламжилсан “Тооцооны үйл ажиллагааны журам”-ын дагуу 2018 оны 12-р сарын 1-ээс Монголын үнэт цаасны биржийн арилжааны төлбөр тооцоо Т+2 горимд шилжлээ.

Эх сурвалж: Монголын үнэт цаасны бирж



2018 онд хөрөнгийн захад шинээр гарсан бүтээгдэхүүнүүдийн захиалга нийлүүлэлтээсээ 3 дахин давжээ

2018 он гарснаас хойш дотоодын хөрөнгийн зах зээл дээр зургаан шинэ бүтээгдэхүүн гарч, олон нийтээс 30 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлсэн байна. Үүнд нийт 85 гаруй тэрбум төгрөгийн буюу нийлүүлэлтээс гурав дахин давсан захиалга ирсэн ажээ.

Мөн Монголын Үнэт Цаасны Биржийн 2018 оны 12 дугаар сарын 10 өдрийн 267 дахь арилжаагаар “Минж проперти” ХХК-ийн “Парк таун” бондын анхдагч зах зээлийн арилжаа амжилттай зохион байгуулагдаж 1 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олон нийтээс татан төвлөрүүлсэн. “Парк таун” бондын арилжааны тайлан мэдээг СЗХ-ны Бүртгэлийн журмын 4.4.11 болон 4.4.13-д заасны дагуу СЗХ-ны зөвшөөрлийн дараа олон нийтэд мэдэгдэх учраас одоогоор захиалгын хэмжээ тодорхойгүй байна.

2017 онд гарсан IPO-нуудын захиалга нийлүүлэлтээсээ дунджаар хоёр дахин давж байжээ. Энэ онд ч мөн анхдагч зах зээлийн захиалгын хэмжээ нийлүүлэлтээ давсаар байна. Монголын хөрөнгийн биржийн мэдээлснээр захиалга нийлүүлэлтээсээ дунджаар гурав дахин илүү байгаа ажээ

Хөрөнгийн зах зээл дээр хамгийн олон шинэ бүтээгдэхүүн гарсан 2018 онд “ЛэндМН” компанийн анхдагч зах зээлийн захиалгын хэмжээ хамгийн өндөр байв. Тус компани олон нийтээс 2.5 тэрбум төгрөг, стратегийн хөрөнгө оруулагчдаас 2.5 тэрбум төгрөгийг тус тус татан төвлөрүүлэхээр IPO гаргасан юм. Харин олон нийтээс ирүүлсэн захиалгын хэмжээ 41.5 тэрбум төгрөгт хүрсэн нь нийт олон нийтээс төвлөрүүлэх хэмжээнээс 16.6 дахин давсан үзүүлэлт болсон. Үүнээс гадна барилгын дулааны материал үйлдвэрлэдэг “Монгол базальт” компанийн анхдагч зах зээлийн хувьцааны захиалга 3.2 дахин давж, 20.4 тэрбум төгрөгт хүрч байжээ.

2019 онд IPO гаргах компаниудын тоо олон байгаагаас гадна давхар бүртгүүлэх сонирхолтой компаниуд ч байгааг Монголын хөрөнгийн биржийн Гүйцэтгэх захирал онцоллоо. Мөн Монголын үнэт цаасны биржийн дараа дараагийн шинэ бүтээгдэхүүнүүд ирэх онд гарах хүлээлттэй байгааг тус биржээс мэдээлсэн юм.

Эх сурвалж: BloombergTv.mn

ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

ҮСХ: Нүүрсний экспорт сарын дүнгээр 38%-иар буурав

Үндэсний статистикийн хорооны мэдээлж буйгаар энэ оны эхний 11 сарын байдлаар манай улсын эрдсийн экспорт 5.6 тэрбум орчим ам.долларт хүрч өмнөх оны мөн үеийнхээс 23.9%-иар өссөн дүнтэй гарлаа. Энэ нь нийт экспортын 86.3%-ийг эрдсийн экспорт бүрдүүлж буй гэсэн үг. Харин нүүрсний экспортын хувьд 2.6 тэрбум ам.долларт хүрч 24.1%-ийн өсөлтийг харуулав.

Нүүрсний экспортын биет хэмжээ оны эхний 11 сард 33.8 сая тоннд хүрсэн байна. Энэ нь өнгөрсөн оны мөн үеийнхтэй харьцуулахад жингийн хувьд 7.9%-иар өссөн дүн болж байгаа юм. Харин сарын дүнгээр авч үзвэл арваннэгдүгээр сарын нүүрсний экспорт 2.46 сая тоннд хүрч өнгөрсөн хоёрдугаар сараас хойших хамгийн доод хэмжээнд хүрлээ. Энэ дүн нь өнгөрсөн аравдугаар сард нүүрсний экспорт 3.97 сая тоннд хүрч байсантай харьцуулахад 38%-иар буурсан үзүүлэлт юм.

Зэсийн баяжмалын экспортын тухайд мөн хугацаанд 1.3 сая тоннд хүрч мөнгөн дүнгээр 1.8 тэрбум ам.долларт хүрчээ. Энэ нь биет хэмжээний хувьд өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад ялимгүй бууралттай боловч орлогын хувьд 26.5%-иар дээшилсэн үзүүлэлт болж байна. Боловсруулсан зэсийн хувьд оны эхний 11 сарын байдлаар 12 орчим мянган тонн бүтээгдэхүүн гадагш нийлүүлж 76 сая ам.долларын орлого олсон байна. Энэ нь жингийн хувьд 18.3%, орлогын дүн нь 11.3%-иар тус тус буурсан болохыг илтгэж байна.

Экспортын дүнгээр гуравдугаарт эрэмбэлэгдэж буй түүхий газрын тосны экспортын тухайд энэ оны эхний 11 сарын байдлаар 5.7 орчим сая баррельд хүрч 367 орчим сая ам.долларын орлого олсон нь жингээр 18.3%-ийн бууралтыг харуулсан бол мөнгөн дүнгээр 7.4%-ийн өсөлттэйгөөр тэмдэглэгдлээ.

Экспортын хэмжээгээр дөрөвдүгээрт бичигдэх төмрийн хүдрийн тухайд эхний 11 сард экспортын биет хэмжээ 6.7 сая тоннд хүрсэн бөгөөд мөнгөн дүнгээр 307 сая ам.доллартай тэнцлээ. Энэ нь жингийн хувьд 20.6%, орлогын тухайд 8.2%-ийн өсөлтийг тус тус харууллаа.

Цайрын хүдэр, баяжмалын экспортын хэмжээ орлогын дүнгээр 183.6 сая ам.доллар, жингээр 113.8 мянган тоннд хүрсэн нь мөнгөн дүн 11.6%, жингээр 4.9%-ийн өсөлтийг үзүүлээ.

Жоншны хүдэр, баяжмалын экспорт оны эхний 11 сарын байдлаар 492.5 мянган тоннд хүрч, 165.8 сая ам.долларт хүрсэн нь жингийн хувьд 75.4%, орлогын дүнгээр 2.3 дахин өссөн дүнтэй гарсан байна.

Алтны экспортын хувьд эхний 11 сарын байдлаар 3.4 тонныг гадагш нийлүүлж 144.5 сая ам.долларын орлого олсон нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 74%-иар буурсан үзүүлэлт болж байна. Гэхдээ Монголбанкны мэдээлж буйгаар эхний 11 сард 18.9 тонн алт худалдан авсан байгаа нь өнгөрсөн оны мөн үеийнхтэй ижил хэмжээнд байгаа юм. Мөн төв банкны мэдээлснээр арванхоёрдугаар сарын 5-ны байдлаар алт худалдан авалт 19.8 тонн болж багагүй хэмжээгээр нэмэгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 3.2%-иар өссөн үзүүлэлт болохыг мэдэгдсэн билээ.

Хар тугалганы хүдэр, баяжмалын экспорт мөн хугацаанд 20.4 мянган тоннд хүрч, 50.7 сая ам.долларт хүрсэн нь жингээр 35.2%, мөнгөн дүнгээр 31.8%-иар тус тус өссөн байна.

Молибденийн баяжмалын тухайд мөн хугацаанд 5.4 мянган тонныг экспортолж, 44.5 сая ам.доллар олсон нь жингийн хувьд 9.2%-иар буурч, 31.7%-иар өссөн дүнтэй байна.

Гянтболдын экспортын тухайд 701.6 тонныг гадагш нийлүүлж, 7.4 сая ам.доллар олсон нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 28.8%, мөнгөн дүнгээр 3.4%-иар тус тус буурсан дүнтэй гарлаа.

Эх сурвалж: MongolianMiningJournal.com

ЕСБХБ нүүрсний төслүүдэд санхүүжилт олгохоо зогсоолоо

Байгаль орчныг хамгаалах зорилгоор нүүрсний төслүүдэд санхүүжилт олгохоо зогсоож байгаагаа Европын сэргээн босголт хөгжлийн банк зарлалаа. Монгол, Польш, Казахстан зэрэг эрчим хүчнийхээ 70 гаруй хувийг нүүрснээс гарган авдаг улсыг өмнө нь тусад нь авч үзэн санхүүжилт олгодог байсан юм.

Хэдий тийм боловч энэ удаагийн шийдвэрийн хүрээнд бүх улсад олгох энэ төрлийн санхүүжилт зогсож байгаа юм байна. Европын сэргээн босголт хөгжлийн банкны шийдвэр гарахаас өмнөхөн Италийн хамгийн том даатгалын компани "Generali" мөн нүүрсээр ажилладаг цахилгаан станцуудын шинэ төсөл болон нүүрсний уул уурхайн бизнест цаашид баталгаа гаргахгүй гэдгээ мэдэгджээ. Хөрөнгө удирдлагын компаниуд болон Төрийн хөрөнгө оруулалтын сангууд мөн байгаль орчныг хамгаалах үүднээс уул уурхайн салбар дахь оролцоогоо багасгах бодлогын өөрчлөлт хийж эхлээд байгаа юм.

Үүний зэрэгцээ Европын Холбоонд нүүрс олборлолтоор тэргүүлэгч "Polska Grupa Gornicza" компани нүүрсийг метанол болгон боловсруулах үйлдвэр барихад 500 сая еврогийн хөрөнгө оруулалт хийх төлөвлөгөөг гаргалаа. Польшийн Засгийн газрын өмчид байдаг тус компани жилд 30 сая тонн нүүрс олборлодог ажээ. Шинэ үйлдвэр нь жилд 1.2 сая тонн нүүрсийг боловсруулах юм байна. Ингэснээр нүүрстөрөгчийн давхар ислийн ялгаруулалтыг 150 мянган тонноор бууруулна гэж тооцоолжээ.

Эх сурвалж: BloombergTv.mn

Goldman Sachs: 2019 онд таваарын зах зээлд ханшийн огцом савлагаа үүсэхгүй

Ирэх онд таваарын зах зээлд 2015 оныхтой адил ханшийн огцом савлагаа үүсэхгүй гэж "Goldman Sachs Group"-ийн шинжээчид таамаглаж байна.

Хэдийгээр БНХАУ-ын эдийн засгийн өсөлтийн хурд саарсан ч ихэнх түүхий эдийн бизнес ашигтай байх төлөвтэй байгааг "Goldman Sachs"-ийн 2019 оны төлөвийн шинэ тайланд онцолжээ. Компаниудын санхүүгийн үзүүлэлт сайжирсан, мөн үйлдвэрлэлийн хүчин чадал нэмэгдэж байгаа зэрэг нь таамаг эерэг гарах гол үндэслэл болсон аж. Үүнээс гадна аж үйлдвэрийн үндсэн түүхий эд гангийн эрэлт таван хувиар буурна гэж таамаглаж байна. БНХАУ-ын Засгийн газрын дэд бүтцийн хөрөнгө оруулалт багассан нь үүний гол шалтгаан гэж "Goldman Sachs"-ийн шинжээчид үзжээ.

БНХАУ-д гангийн нөөц 70 хүртэлх хувиар өсөж магадгүй гэсэн таамгийг "Goldman Sachs" наймдугаар сард гаргаж байсан юм. Хэдий тийм боловч энэ нь гангийн үйлдвэрлэлээр тэргүүлэгч "Baoshan Iron & Steel" компани өвлийн улирлын нийлүүлэлтийн хязгаарлалтад орох эсэхээс голлон шалтгаалах юм байна. Эрэлт талаасаа хөнгөн цагаан, нүүрсний эрэлт 2018 оны түвшинтэй ойролцоо байна гэж таамаглажээ.

Эх сурвалж: BloombergTv.mn

БУСАД МЭДЭЭ

ҮСХ: Монгол улсын эдийн засгийн 11-р сарын байдал

Мөнгө, зээл, үнэт цаас

Мөнгөний нийлүүлэлт (М2) 2018 оны 11 дүгээр сарын эцэст 18.6 их наяд төгрөг болж, өмнөх сараас 321.8 (1.8%) тэрбум төгрөг, өмнөх оны мөн үеэс 3.8 (25.9%) их наяд төгрөгөөр өссөн байна.

Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө 2018 оны 11 дүгээр сарын эцэст 895.1 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 7.3 (0.8%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 70.4 (8.5%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2018 оны 11 дүгээр сарын эцэст 16.7 их наяд төгрөг болж, өмнөх сараас 263.1 (1.6%) тэрбум төгрөг, өмнөх оны мөн үеэс 3.2 (23.9%) их наяд төгрөгөөр өссөн байна.

Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 2018 оны 11 дүгээр сарын эцэст 974.0 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 70.1 (6.7%) тэрбум төгрөгөөр буурч, өмнөх оны мөн үеэс 80.2 (9.0%) тэрбум төгрөгөөр өсжээ. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 5.8 хувийг эзэлж, өмнөх сараас 0.5 пунктээр, өмнөх оны мөн үеэс 0.8 пунктээр тус тус буурсан байна.

Улсын нэгдсэн төсөв

Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, тусламжийн нийт хэмжээ 2018 оны эхний 11 сард 8.2 их наяд төгрөг, зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 8.0 их наяд төгрөгт хүрлээ. Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 2017 оны эхний 11 сард 980.4 тэрбум төгрөгийн алдагдалтай гарч байсан бол 2018 оны эхний 11 сард 266.4 тэрбум төгрөгийн ашигтай гарлаа. Энэ оны 11 дүгээр сард өмнөх сараас улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, тусламжийн нийт хэмжээ 303.2 тэрбум төгрөг, нийт зарлага, цэвэр зээлийн хэмжээ 33.9 тэрбум төгрөгөөр буурчээ.

Татварын нийт орлого 7.4 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1.7 (30.8%) их наяд төгрөгөөр өсөхөд нэмэгдсэн өртгийн албан татвар 483.6 (32.7%) тэрбум төгрөг, орлогын албан татвар 437.2 (30.5%) тэрбум төгрөг, нийгмийн даатгалын орлого 264.3 (22.9%) тэрбум төгрөг, онцгой албан татвар 230.5 (50.1%) тэрбум төгрөг, гадаад үйл ажиллагааны орлого 160.8 (35.3%) тэрбум төгрөг, бусад татвар, төлбөр хураамжийн орлого 134.9 (25.5%) тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Улсын нэгдсэн төсвийн орлогын 81.4 хувийг татварын орлого, 9.6 хувийг татварын бус орлого, 6.7 хувийг ирээдүйн өв сангийн орлого, 2.2 хувийг тогтворжуулалтын сангийн орлого эзэлж байна.

Төлбөрийн тэнцэл

Төлбөрийн тэнцлийн урсгал ба хөрөнгийн дансны тэнцэл 2018 оны эхний 9 сард урьдчилсан гүйцэтгэлээр 1.1 тэрбум америк долларын алдагдалтай гарч, өмнөх оны мөн үеэс 600.5 сая америк доллараар өсжээ.

Нийт төлбөрийн тэнцэл 2018 оны эхний 9 сард 475.3 сая америк долларын алдагдалтай гарч, өмнөх оны мөн үеэс 677.2 сая америк доллараар өссөн байна.

Гадаад худалдаа

Монгол Улс 2018 оны эхний 11 сард 155 улстай худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 11.9 тэрбум америк доллар, үүнээс экспорт 6.5 тэрбум америк доллар, импорт 5.4 тэрбум америк долларт хүрлээ. Харин 2018 оны 11 дүгээр сард экспорт 535.9 сая америк долларт, импорт 495.9 сая америк долларт хүрч, өмнөх сараас экспорт 126.1 (19.0%) сая америк доллараар, импорт 28.6 (5.5%) сая америк доллараар тус тус буурсан байна. Нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 2.3 (23.6%) тэрбум америк доллар, үүнээс экспорт 794.2(14.0%) сая америк доллараар, импорт 1.5 (37.6%) тэрбум америк доллараар тус тус өссөн байна. Гадаад худалдааны тэнцэл 2017 оны эхний 11 сард 1.8 тэрбум америк долларын ашигтай гарч байсан бол 2018 оны эхний 11 сард өмнөх оны мөн үеэс 672.6 (37.7%) сая америк доллараар буурч, 1.1 тэрбум америк доллар болжээ. Гадаад худалдааны тэнцэл 2018 оны 11 дүгээр сард 40.0 сая америк долларын ашигтай гарч, өмнөх оны мөн үеэс 61.8 (60.7%) сая америк доллараар буурсан байна.

Экспорт 2018 оны эхний 11 сард өмнөх оны мөн үеэс 794.2 сая америк доллараар өсөхөд эрдэс бүтээгдэхүүний экспорт 1.1 тэрбум америк доллар, нэхмэл бүтээгдэхүүний экспорт 79.3 сая америк доллараар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Харин импорт өмнөх оны мөн үеэс 1.5 тэрбум америк доллараар өсөхөд эрдэс бүтээгдэхүүний импорт 301.0 сая америк доллар, үүнээс дизелийн түлш 128.8 сая америк доллар, машин, механик төхөөрөмж, цахилгаан хэрэгсэл, тэдгээрийн сэлбэг, эд анги 365.4 сая америк доллараар, тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд анги 246.3 сая америк доллараар, үндсэн төмөрлөг, түүгээр хийсэн бүтээгдэхүүний импорт 203.5 сая америк доллараар өссөн нь голлон нөлөөлжээ.

Үнэ

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2018 оны 11 дүгээр сард улсын хэмжээнд өмнөх сараас 1.8 хувиар өсөж, өмнөх оны эцсээс 7.5 хувь, өмнөх оны мөн үеэс 8.1 хувиар өссөн байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2018 оны 11 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 8.1 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 7.6 хувь (согтууруулах бус ундааны дэд бүлгийн үнэ 5.3 хувь, сүү, сүүн бүтээгдэхүүн, өндөгний дэд бүлгийн үнэ 9.8 хувь), согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 8.1 хувь, тээврийн бүлгийн үнэ дүнгээрээ 11.0 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 16.0 хувь (цахилгаан, хийн болон бусад түлшний дэд бүлгийн үнэ 23.1 хувь), эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 12.7 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2018 оны 11 дүгээр сард өмнөх оны эцсээс 7.5 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 7.2 хувь (мах, махан бүтээгдэхүүн 20.7 хувь), согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 7.7 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК нь мэдээллийн үнэн бодит байдалд баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК хариуцлага хүлээхгүй болно.